

МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 11

УЛСАН БАТААГ УОТ

Төслийн удирдах хороог шинэчлэн  
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 80, 129, 261 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн барих Тавантолгойн цахилгаан станцын төслийн удирдах хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Төслийн удирдах хорооны дарга:

Д.Чимэддорж -Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Гишүүд:

Н.Болдхүү	-Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Насантогтох	-Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Д.Даваасамба	-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга /зөвшилцсөнөөр/
Г.Батхүрэл	-Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга /зөвшилцсөнөөр/
Д.Даваадорж	-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүрэг гүйцэтгэгч /зөвшилцсөнөөр/
Г.Энхтайван	-Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн
Ж.Жанарбаатар	-Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Д.Батбилэг	-Тавантолгойн цахилгаан станцын төслийн нэгжийн захирал
Л.Эрхэмзаяа	-“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дэд бүтэц, тээвэр ложистикийн газрын захирал

10960000


Төслийн удирдах хорооны нарийн бичгийн дарга:

Б.Алтангэрэл -Тавантолгойн цахилгаан станцын төслийн нэгжийн инженер

2. Уг төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, төслийн хүрээнд хийгдэх ажлын явц болон шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тухай бүр авч хэлэлцэн шийдвэрлэж, төсөл хэрэгжүүлэх нэгжийг чиглэл, удирдамжаар ханган ажиллахыг Төслийн удирдах хороо /Д.Чимэддорж/-нд даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2013 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 60 дугаар тушаалын 1 болон 2 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



П.ГАНХҮҮ